



ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Огноо: 2020.04.28

Тендер шалгаруулалт
/ гэрээний нэр:

Тендер шалгаруулалт
/ гэрээний дугаар:

Технологийн удирдлагын системын программын тоног
төхөөрөмж

АДС/202001008

Нэг. УНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Технологийн удирдлагын системын программын тоног төхөөрөмж**-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг *2020 оны 05-р сарын 06-ны өдрийн 09цаг 00 мин -аас өмнө tender.gov.mn цахим хаягаар ирүүлнэ.*

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан *2020 оны 05-р сарын 06-ны өдрийн 09цаг 30 мин -т* нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх. *Toоцохгүй*

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Амгалан дулааны станц ТӨХК-ийн өөрийн байр БЗД-ийн 8-р хороо, УС15-ийн 1-1 тоот

(77111251, Хангамжийн хэлтэс)

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх-/д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

(а) Унийн санал;
(б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тендерийн үнэ | 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэгчийн төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтаасан гэж үзнэ.
4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөх буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна. |
| 5. Унийн саналын хүчинтэй байх хугацаа | 5.1. Унийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.


ТОӨЗ-ны холбогдох заалт	Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ
ТОӨЗ 1.1	<p>Сүүлийн [2019 оны] санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/;</p> <ol style="list-style-type: none"> Сүүлийн [1 жилийн] туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <i>Улсын бүртгэлийн гэрчилгээ хуулбар нотариатаар баталгаажуулсан байх.</i>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>цахимаар tender.gov.mn сайтаар ирүүлэх</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Баянзүрх дүүрэг 8-р хороо УС15-ийн 1-1 Амгалан дулааны станци ТӨХК-ийн өөрийн байр</i></p> <p>Огноо: <i>2020 оны 05-р сарын 06 өдрийн 09 цаг 00 мин өмнө тендерийг цахимаар хүлээн авна.</i></p> <p>Цаг: хүлээн авах эцсийн хугацаа: <i>09 цаг 00мин</i></p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>БЗД-ийн 8-р хороо, УС-15-1-1 тоот Амгалан дулааны станци ТӨХК-ийн өөрийн байр 103 тоот</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Өөрийн байрны 1 давхарт 103 тоот Хангамжийн хэлтэс</i></p> <p>Огноо: <i>2020 оны 05-р сарын 06-ны одор</i></p> <p>Цаг: <i>09 цаг 30 мин</i></p>
ТОӨЗ 2.3	<p>Долдугаар бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <i>Улсын бүртгэлийн гэрчилгээ нотариатаар баталгаажуулсан байх.</i> <i>Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан, аудитаар баталгаажуулсан дүгнэлтийн хамт байх /2019 он/</i> <i>Шүүхийн тодорхойлолт</i> <i>Татварын тодорхойлолт /өргүй байх/</i> <i>Гэрээний тусгай ба ерөнхий нохцолийг зөвшиөөрсөн мэдэгдэл</i> <i>Техникийн тодорхойлолтын шаардлагийн дагуу багц материалын ирүүлэх</i> <p style="margin-left: 40px;"><i>a) Нийлүүлэлтийн хугацаа болон хуваарь</i></p> <p style="margin-left: 40px;"><i>b) Нийлүүлэх барааны баталгаа</i></p>
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас

	<p>бүрдэнэ: Тендер шалгаруулалт ТУСП Тоног төхөөрөмж / гэрээний нэр:</p> <p>Тендер шалгаруулалт / гэрээний дугаар: АДС/202001008</p>
--	--

БАТЛАВ.
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛТЫН СОД
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР АУДИАНЫ САНИ Ч.ДОГТСАЙХАН

Siemens 321-1FH00-0AA0 DO оролтын тодулийн техникийн шаардлага


1	Ачааллын хүчдэл	230 V; 120/230 В гүйдэл
2	Оролтын гүйдэл	29 mA
3	Дижитал гаралтууд	16
4	Нэг зэрэг хянаагдах гаралтын тоо	16
5	Цагийн давтамж	66 MHz
6	Оролтуудын тоо	4
		2
		6
		16
		32
7	Гаралтын стационы тоо	63 station - 1 rack - 3 Plus Modbus сүлжээ
8	electrical connection	1 эм холбогч, холбогчийн төрөл: SUB-D 9 нь plus modbus холболтыг хийхэд ашиглана.
		2 эм холбогч, холбогчийн төрөл: SUB-D 9 modbus bus холболтыг хийхэд ашиглана.



Тодорхойлолт гаргасан: ТУСП Инженер... Ч.Пүрэв

БАТЛАВ: ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР САНДААНЫ Ч.ПОГТСАЙХАН

"OMRON OC2011 гаралтын модул"-ын техникийн тодорхойлолт



1	I/O систем (I/O system)	CJ I/O Bus
2	Өргөтгөх нэгжийн төрөл (Expansion unit type)	Basic I/O Unit
3	Модулийн төрөл (Type of module)	Digital I/O
4	Дижитал оролтын тоо (Number of digital inputs)	0
5	Дижитал оролтын төрөл (Digital input type)	None
6	Гаралтын зөвшөөрөгдөх хүчдэл (Permitted voltage at output)	5-250 V
7	Дижитал гаралтын тоо (Number of digital outputs)	16
8	Дижитал гаралтын төрөл (Digital output type)	Relay NO
9	Гаралтын гүйдэл (Output current)	2 A
10	Гаралтын багшио залгалтын хамгаалалт (Short-circuit protected outputs)	NO
11	I/O холболтын төрөл (I/O connection type)	Screw
12	I/O холбогчийн тоо (Number of I/O connectors)	1
13	I/O холбогч салдаг эсэх (Detachable I/O connector)	YES
14	Аюулгүй ажиллагааны функцийн тохиромжтой байдал (Suitable for safety functions)	NO
15	COM терминалын тоо (Number of COM terminals)	2
16	Өндөр (Height)	90 mm
17	Өргөн (Width)	31 mm
18	Зузаан (Depth)	89 mm
20	Цэвэр жин (Product Weight)	118 g

Тодорхойлолт гаргасан: ТУСП Инженер... А.Батзаяа

БАТЛАВ: ТЭРГҮҮН ЭЛЗАКИРАЛ БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



"OMRON PA204 тэжээлийн блок"-ын техникийн тодорхойлолт



1	Брэнд нэр /Brand Name	Omron Electronics
2	Үйлдвэрлэгчийн дугаар /MFR Part Number	C200HW-PA204
3	Олон улсын стандарт, бүтээгдэхүүн үйлчилгээний код /UNSPSC	39121004
4	Барааны төрөл /Item	Power Supply Unit
5	Сери /Series	C200HW
6	Гаралтын чадал /Power Output	30 watt
7	Оролтын хувьсах гүйдэл /Input Ratings	100 - 240 VAC
8	Гаралтын тогтмол гүйдэл /Output Ratings	5 VDC, 4.6 amp
9	Стандарт / Зөвшөөрөл (Standard/ Approvals)	UL Listed, CSA Certified, CE Certified

Тодорхойлолт гаргасан: ТУСП Инженер...А.Батзаяа

БАТЛАВ: ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ
БӨГӨӨД ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Ч.ЦОГСАЙХАН



**Вагон хөмрөгчийн удирдлагын системийн Schneider 140CPS11420
тэжээлийн блокын техникийн тодорхойлолт**

Input voltage (Хүчдэлийн оролт)	115 V (93...132 V) AC 47...63 Hz 230 V (170...276 V) AC
Input current (Гүйдлийн оролт)	1300 mA at 115 V 750 mA at 230 V
Inrush current (Огцом гүйдэл)	19 A 230 V 38 A 115 V
Rated power in VA (Волт амперийн харьцаа)	130 VA
Associated fuse rating (Холбоотой гал хамгаалагчийн зэрэглэл)	2 A, slow-blow (2A удаан-үлээх)
Harmonic distortion (Гармоник гажуудал)	<= 10 % of fundamental rms value (Үндсэн RMS утгийн 10%-иас ихгүй)
Output voltage (Хүчдэлийн гаралт)	5.1 V DC (5.1 В тогтмол)
Power supply output (Цахилгаан хангамжийн гаралт)	current 11 A 60 °C standalone (гүйдэл 11 A 60 °C дангаар) 20 A 60 °C summable (гүйдэл 20A 60 °C хураангуй байдлаар)
Output overvoltage protection (Гаралтын хэт хүчдэлээс хамгаалах)	Internal (Дотоод)
Output overload protection (Гаралтын хэт ачааллаас хамгаалах)	Output overload protection Internal (Гаралтын хэт ачааллаас Дотоод хэсгийг хамгаалах)
Alarm output (Гаралтын анхааруулга)	1 NC, 6 A, 220 V power supply fault (1 NC, 6 A, 220 В цахилгаан тэжээлийн алдаа)
Local signalling (Өөр дээрхи сигнал)	1 LED (green)power (PWR OK) (1 лед тэжээлийн гэрэл (тэжээл ОК гэдгийг илэрхийлнэ))
Marking (Тэмдэглэгээ)	CE
Module format (Модулийн формат)	Standard (Стандарт)
Net weight (Цэвэр жин)	0.65 kg /0.65кг/

Environment (Байгаль орчин)


Standards (Стандарт)	UL 508 CSA C22.2 No 142
Product certifications (Бүтээгдэхүүний гэрчилгээ)	CUL
Resistance to electrostatic discharge (Электростатикийн эсэргүүцэл)	4 kV contact conforming to IEC 801-2 (IEC 801-2 стандартын дагуу 4Кв контакт) 8 kV on air conforming to IEC 801-2 (IEC 801-2 стандартын дагуу 8Кв агаараар)
Resistance to electromagnetic fields (Цахилгаан соронзон орны эсэргүүцэл)	10 V/m 80...2000 MHz conforming to IEC 801-3 (10 В/м 80...2000 Мгц IEC 801-3 стандартын дагуу)

Ambient air temperature for operation (Ажиллагааны үеийн орчны агаарын температур)	0...60 °C
Ambient air temperature for storage (Хадгалалтын үеийн орчны агаарын температур)	-40...85 °C
Relative humidity 95 % without (Харьцангуй чийгшил 95% -гүй)	95 % without condensation (конденсацгүй 95%)
Operating altitude (Ажиллах өндөрлөг)	<= 5000 m (5000 метрээс хэтрэхгүй)

БОЛОВСРУУЛСАН:ТУСПИ

Б.БАРАС

БАТЛАВ: ТЭРГҮҮНДЭЛЗХИРАЛ БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР УЧИТААН Ч.ЦОГТСАЙХАН



"OMRON ID2011 оролтын модул"-ын техникийн тодорхойлолт

1	I/O систем (I/O system)	CJ I/O Bus
2	Өргөтгөх нэгжийн төрөл (Expansion unit type)	Basic I/O Unit
3	Модулийн төрөл (Type of module)	Digital I/O
4	Дижитал оролтын тоо (Number of digital inputs)	16
5	Дижитал оролтын төрөл (Digital input type)	PNP/NPN
6	Оролтын зовшоөрөгдөх хүчдэл (Permitted voltage at input)	20.4-26.4 V
7	OFF/ON хоцрогдол (OFF/ON delay)	0-32 ms
8	Дижитал гаралтын тоо (Number of digital outputs)	0
9	Дижитал гаралтын төрөл (Digital output type)	None
10	Гаралтын гүйдэл (Output current)	0 A
11	Гаралтын багино залгалтын хамгаалалт (Short-circuit protected outputs)	NO
12	I/O холболтын төрөл (I/O connection type)	Screw
13	I/O холбогчийн тоо (Number of I/O connectors)	1
14	I/O холбогч салдаг эсэх (Detachable I/O connector)	YES
15	Аюулгүй ажиллагааны функцийн тохиromжтой байдал (Suitable for safety functions)	NO
16	COM терминалын тоо (Number of COM terminals)	2
17	Өндөр (Height)	90 mm
18	Өргөн (Width)	31 mm
19	Зузаан (Depth)	89 mm
20	Цэвэр жин (Product Weight)	60 g

Тодорхойлолт гаргасан: ТУСП Инженер.....А.Батзаяа

БАТЛАВ: ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ
БӨГӨӨД ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Ч.ЦОГТСАЙХАН

Нуруулдан овоолхын удирдлагын системийн Siemens CP343 Ethernet Card-ийн техникийн тодорхойлолт

Number (Тоо)	1 x PROFINET interface with 2 port switch (1 PROFINET интерфейс нь 2 порттой)
	2 x RJ-45 jacks (2 ширхэг RJ-45 жак)
	10 / 100 Mbps (10-100 Мбт)
Execution /Гүйцэтгэл/	When working with PROFINET IO and cyclic transfer, the transmission speed of 100 Mbps full duplex is mandatory. (PROFINET оролт/гаалт болон цикл дамжуулагчтай ажиллахдаа бүтэн дуплексийн 100 Мбт/сек дамжуулах хурдтай байх шаардлагатай.) Aging time: 5 minutes (идэвхгүй Мак хаягийг хадгалах хугацаа: 5 минут) Special features of the X1P1R and X1P2R ports(X1P1R болон X1P2R портуудын тусгай онцлогууд) : Integration in ring topology/MRP possible (Цагираг топологийн интеграчлал/MRP боломжтой)
Electrical data (Цахилгаан хангамжийн мэдээлэл)	
Supply voltage (Хүчдэлийн хангамж)	External power supply (Гадны тэжээл хангамж):24 VDC /24В тогтмол Permitted range: +20.4 V to +28.8 V / +20.4 Вт -> + 28.8 В From backplane bus: 5 VDC/5В тогтмол
Current consumption (Гүйдэл зарцуулалт)	From external power supply (Гадны тэжээлийн хангамж): 200 mA maximum /200М From backplane bus (Суурь ракнаас): 200 mA maximum /200mA
Effective power loss (Цахилгаан алдагдал)	5.8 W/ 5.8 Вт
Permitted ambient conditions (Хүрээлэн буй орчны нөхцөл)	
Ambient temperature (Орчны температур)	During operation with the rack installed horizontally (Ажиллах үед рак дээр хөндлөнгөөр суурьлагдсан байхад): 0 °C to +60 °C During operation with the rack installed vertically (Ажиллах үед рак дээр босоогоор суурьлагдсан байхад): 0 °C to +40 °C During storage (Агуулхад хадгалсан байхад): -40 °C to +70 °C During transportation (Тээвэрлэлтийн үед): -40 °C to +70 °C

Relative humidity (Харьцангуй чийгшэл)	During operation (Ажиллагааны үед): ≤ 95 % at 25 °C, no condensation (25 хэмд конденсацгүй, 95% ихгүй байх)
Operating altitude (Ажиллах өндөрлөг)	During operation (Ажиллагааны үед): ≤ 2,000 m above sea level/ далайн түвшнээс 2000 ихгүй
Design, dimensions and weight (Дизайн, хэмжээ болон жин)	
Module format (Модулийн формат)	Compact module for S7-300, single width (S7-300-ийн модуль, өргөн нь нэг)
Degree of protection (Хамгаалах зэрэг)	IP20
Weight	Approx. 220 g (оиролцоогоор 220г)
Dimensions/Хэмжээ (W x H x D ,өргөн х өндөр x урт)	40 x 125 x 120 mm
Installation options (Суулгах сонголтууд)	Mounting in an S7-300 rack (S7-300-ийн ракт суурьлуулах)

БОЛОВСРУУЛСАН:ТУСПИ

Б.БАРАС

БАТЛАВ: ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ
БӨГӨӨД ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Ч.ЦОГТСАЙХАН

Түлш дамжуулахын удирдлагын системийн General Electric
IC695ETM001 Et-ийн техникийн тодорхойлолт

Ethernet processor speed (процессорын хурд)	200 MHz
Connectors (Холболтууд)	1. Station Manager (RS-232) Port: 9-pin female D-connector (RS-232 порт: 9 шүдтэй эм D холболттой.)/ 2. Two 10BaseT / 100BaseTX Ports: 8-pin female shielded RJ-45 (2 ширхэг 10-100Мбт порт: 8 шүдтэй RJ-45 эм оролттой)
LAN	IEEE 802.2 Logical Link Control Class I IEEE 802.3 CSMA/CD Medium Access Control 10/100 Mbps
Number of IP addresses (IP хаягийн тоо)	1
Number of Ethernet Port Connectors (Ethernet портын тоо)	Two. both are 10BaseT/100BaseTX with auto-sensing RJ-45 connection (2 ширхэг 10-100Мбт порт: 8 шүдтэй авто мэдрэгчтэй RJ-45 холболттой)
Embedded Ethernet Switch	Yes – Allows daisy-chaining of Ethernet nodes.
Serial Port (Сериал порт)	Station Manager Port (Стайшины менежер порт): RS-232 DCE, 1200 – 115,200 bps.

БОЛОВСРУУЛСАН: ТУСПИ

Б.БАРАС

БАТЛАВ:
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БОРОӨД
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Ч.ЦӨГТСАЙХАН




Siemens PS307 маркийн тээжээлийн блокийн техникийн шаардлага


Оролтын параметрүүд / Input parameters/

Оролтын хүчдэл	120/230 VAC (автоматаар шилжүүлнэ)
Давтамж	47 Гц-ээс 63 Гц хүртэл
Орлтын гүйдэл	120 Вольт үед 2.3 A 240 Вольт үед 1.2 A

Гаралтын параметрүүд /Output parameters/

Гаралтын хүчдэл	24 V ± 3%
Гаралтын гүйдэл	5A




Тодорхойлолт гаргасан: ТУСП Инженер...  Ч.Пүрэв

УЛААНБААТАР хот
БАТЛАВ:
 ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛЫН ОД
 ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР *Ч.Пүрэв* Ч.ДОГТСАЙХАН

Siemens 321-1FH00-0AA0 DO оролтын тодулийн техникийн шаардлага

1	Ачааллын хүчдэл	230 V; 120/230 В гүйдэл
2	Оролтын гүйдэл	29 mA
3	Дижитал гаралтууд	16
4	Нэг зэрэг хянаагдах гаралтын тоо	16
5	Цагийн давтамж	66 MHz
6	Оролтуудын тоо	4
		2
		6
		16
		32
7	Гаралтын стационы тоо	63 station - 1 rack - 3 Plus Modbus сүлжээ
8	electrical connection	1 эм холбогч, холбогчийн төрөл: SUB-D 9 нь plus modbus холболтыг хийхэд ашиглана.
		2 эм холбогч, холбогчийн төрөл: SUB-D 9 modbus bus холболтыг хийхэд ашиглана.



Тодорхойлолт гаргасан: ТУСП Инженер *Ч.Пүрэв* ч.Пүрэв

Долоо. ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Амгалан дулааны станц ТӨХК-ын гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн унийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гол түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шуухэд нэхэмжлэл гаргана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.

7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдолын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдолыг арилгаж дуусах хуртэл сунгана.

9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдолыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнэ. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.
Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.
Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлагы**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохицуулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг сүутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнэ.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Гэрээний нэр: Ухаалаг дэлгэц дугаар: AДС/202001011
ГЕН 2.1	Бараа материал хүргэгдэх эцсийн цэг: Амгалан дулааны станц ТӨХК
ГЕН 3.1	Урьдчилгаа төлбөр: Олгохгүй
ГЕН 4.1	Нийлүүлэгч нь тээвэрлэлт болон бараа хүлээн авах явцад гарсан гэмтэл согог, өнгө узэмжийн бүрэн бүтэн байдлыг 100% хариуцана.
ГЕН 5.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 6-аас доошгүй хоногийн дараа гэрээ байгуулах ба гэрээнд заагдсан хугацаанд барааг нийлүүлэх үүрэг хүлээнэ.
ГЕН 6.1	Чанарын баталгаат хугацаа 90 хоногоос багагүй байна.
ГЕН 7.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,05% байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 5-10 % хэтрэхгүй байна.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дун: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;

5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзольд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]